



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/425

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 7/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний их баяр наадмын өдрүүдэд “Цэвэрхэн хоггүй наадацгаая” нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулахад зориулан 1,200,000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 1,200,000 төгрөг (нэг сая хоёр зуун мянга/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 7/02 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 2.2-д тусгагдсан Хогны менежментийг сайжруулах төслийн дэмжлэг /хөтөлбөр/-ээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны
07 дугаар сарын 05-ны өдрийн
А/425 дугаар захирамжийн
хавсралт

АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗАРЦУУЛАЛТЫН ЗАДАРГАА

Зарцуулалт	Хэмжих нэгж /ширхэг/	Нэгж үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
Хогны уут	80	1000	80 000
Бээлий	80	500	40 000
Маск	80	500	40 000
Хавчаар	40	5000	200 000
Малгай	40	10 000	400 000
Футболк	40	10 000	400 000
Бичилт	40	1000	40 000
Нийт дүн			1 200 000